



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.02.09 № 08

Төрийн албан хаагчдын цалингийн талаар

Монгол Улсын Засгийн газар бодлого боловсруулж, шийдвэр гаргахдаа олон нийтийн санал, шүүмжлэл, эсэргүүцлийг түр зуур аргацаан гал унтраах байдлаар ажиллаж байгаа нь туйлын харамсалтай байна. Тухайлбал, багш, эмч нар цалингаа, ахмадууд тэтгэврээ нэмэгдүүлэхийн тулд ажил хаялт зарлах, жагсах зэрэг арга хэмжээ авч тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэж болно. Харин эмч, багш нараас бусад төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид жагсаж, тэмцэж чадаагүйгээрээ цалингаа нэмэгдүүлэх боломжгүй үлдэж байгаа нь тогтолцоо гажиж байгаагийн илрэл.

Иймд инфляцтай уялдуулж төрийн албаны бүхий л ажилтан, албан хаагчийн цалин бодитоор нэмэгддэг байх тогтолцоог төлөвшүүлэх шаардлагын улмаас төрийн бүх ангилал, зэрэглэлийн албан хаагчдын цалин урамшуулалтай холбоотойгоор дараах асуулгыг Танд тавьж байна.

1.Төрийн албаны бүхий л ангилал, зэрэглэлийн цалинг нэмэгдүүлэх эсэх талаар Засгийн газрын баримталж буй бодлого, авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний талаар;

2.Төрийн үйлчилгээний албан хаагчдаас зөвхөн багш, эмч нарын цалинг нэмсэн эсэх, тэдний цалингийн зэрэглэл, нэмэгдэлд орсон өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3.Төрийн үйлчилгээний бусад албан хаагчид ялангуяа орон нутагт ажиллаж байгаа цаг уур, орчны шинжилгээний байцаагч нарын цалин, нийгмийн баталгааг сайжруулах талаар үе шаттай, эхлэх, хэрэгжүүлэх зэрэг тодорхой хугацаатай төлөвлөсөн арга хэмжээ байгаа эсэх;

4.Төрийн албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл авах ёстой боловч орон нутагт ажиллаж байгаа зарим төрийн албан хаагч нар орон нутгийн нэмэгдэл авдаггүй талаар гомдол их гарч байна. Иймд орон нутгийн нэмэгдэл авдаггүй төрийн албан хаагчдын талаарх судалгаа, олгодоггүй шалтгаан, тэднийг цаашид орон нутгийн нэмэгдэлд хамруулах эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд хариуг ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.АЛТАНГЭРЭЛ

2026000022